

НИЙСЛЭЛИЙН СПОРТЫН ХОРОО

Иргэдээс ирүүлсэн хүсэлтийн шийдвэрлэлтийн тайлан

/2020 оны байдлаар эцсийн байдлаар/

1. 2020 оны 01 дүгээр сарын 01-нээс 12 дугаар сарын 25-ны байдлаар иргэдээс 1 санал, 2 гомдол, 9 хүсэлт ирүүлсэн нь өмнөх оны мөн үеийнхтэй харьцуулахад 1 санал, 2 гомдол, 3 хүсэлтээр их байна.

Үзүүлэлт	2019.01.01 – 12.25		2020.01.01 – 12.25	
	Ирсэн тоо	Хувь	Ирсэн тоо	Хувь
Ирсэн хүсэлтийн тоо	6	100%	12	100%

2. 2020.01.01-нээс 2020.12.25-ны хооронд иргэдээс ирүүлсэн 1 санал, 2 гомдол, 9 хүсэлтийг программд бүртгэж оруулан өдөрт нь удирдлага, холбогдох ажилтнуудад шилжүүлж, шийдвэрлэлтийн мэдээг 14 хоног бүр байгууллагын удирдлагад танилцуулж, мэдээлэл хийснээр санал, гомдол, хүсэлтийг хугацаанд нь шийдвэрлэсэн.

3. 2020 оны 06 дугаар сарын 03-ны өдрийн 17:12 цагт ирүүлсэн биеийн тамир, спортын үйл ажиллагаатай холбогдолтой нэг гомдлыг ажлын 6 хоног хэтрүүлэн хүлээн авч, зөрчил гаргасан. Уг гомдлыг хүлээн авсан хугацаандаа шийдвэрлэсэн болно.

4. 2019 оны 12 сарын 10-нд ирүүлсэн өргөдлийг шийдвэрлэхэд явцын тэмдэглэл хөтлөөгүй, 2020 оны 06 дугаар сарын 03-ны өдөр 1 гомдол ирснийг хугацаанд нь хүлээн авалгүй зөрчил гаргасан Мэдээллийн технологи, техник тоног төхөөрөмж, гадаад харилцаа, хамтын ажиллагаа, байгууллагын ил тод байдал хариуцсан мэргэжилтэн Н.Өлзийжаргалд байгууллагын даргын тушаалаар хариуцлага тооцож, арга хэмжээ авч ажилласан.

5. Нийслэлийн Спортын хороонд иргэн, байгууллагаас ирүүлсэн санал, гомдол, хүсэлтийн шийдвэрлэлтийн дундаж хугацааг өмнөх улирлаас 3 хоног 06 цаг 18 минут болгож багасгасан.

ТАНИЛЦСАН:
ДАРГА

Ж.ГАНБОЛД

ХЯНАСАН:
СПОРТЫН ХӨГЖЛИЙН
ХЭЛТСИЙН ДАРГА

С.САРАНЦЭЦЭГ

ТАЙЛАН МЭДЭЭ ГАРГАСАН:
МЭРГЭЖИЛТЭН

Н.ӨЛЗИЙЖАРГАЛ